

МОНГОЛЫН БАЙЛДАН ДАГУУЛЛЫН ҮЕИЙН
МЭДЭЭЛЛИЙН ДАЙНЫ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

ц.Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

Түлхүүр үг: мэдээллийн дайн, штабын дайн, сэтгэл зүйн дайн, кибер орон зай

«Мэдээллийн дайн» хэмээх нэр томъёог анх 1976 онд Америкийн шинжээч Томас Рона хэрэглэжээ. Boeing компанид зориулж бичсэн «Зэвсэглэлийн тогтолцоо ба мэдээллийн дайн» тайландаа тэрээр мэдээллийн дэд бүтэц нь АНУ-ын эдийн засгийн гол бүрэлдэхүүн хэсэг болж байгааг онцлон тэмдэглэсэн байдаг. Судлаачид энэхүү тайланг «мэдээллийн дайн» хэмээх нэр томъёо анх хэрэглэгдсэн тохиолдол гэж үздэг¹.

Т.Ронагийн тайлан шинжээчдийн, нэн ялангуяа цэргийн мэргэжилтнүүдийн анхаарлыг ихээр татсан байна. 1980 оноос эхлэн АНУ-ын агаарын цэргийн хүчнийхэн «мэдээллийн дайн» хэмээх ойлголтыг дагнан судлах болжээ. 1980-аад оны сүүлээр «Хүйтэн дайн» дуусгавар болсонтой холбогдуулан АНУ-ын Зэвсэгт хүчин «мэдээллийн дайн»-ыг шинэ нөхцөл байдал, шинэ зорилго, зорилттой уялдуулан сонирхох болсон байна. 1991 онд Иракт «Цөлийн шуурга» ажиллагаа

явагдах болсноор мэдээллийн шинэ технологиуд ихээхэн эрэлт хэрэгцээтэй болжээ. Тэгэхдээ «мэдээллийн дайн»-ыг байлдааны ажиллагааны нэг бүрэлдэхүүн хэсэг мэтээр авч үзэх хандлага зонхилсон юм. Харин энэ нэр томъёог АНУ-ын Батлан хамгаалахын сайд Ричард Чейни 1992 оны 12-р сарын 21-нд удирдамждаа дурдсанаар албан ёсны эргэлтэнд оруулсан байна².

1996 онд Пентагоны шинжээч Роберт Банкер XXI зууны АНУ-ын зэвсэгт хүчний шинэ номлолд зориулсан «Force XXI» илтгэлдээ байлдааны ажиллагааны театрыг уламжлалт орон зай, кибер орон зай гэж хуваажээ. Тэгэхдээ уламжлалт орон зайг нөхөх зорилго бүхий кибер орон зай нь эсрэг талын зэвсэгт хүчнийг аюулгүйжүүлэх, дарах үүрэгтэй гэж Банкер үзсэн бөгөөд уламжлалт хэлбэрээсээ илүү ач холбогдолтой болохыг дурдсан байна.

Улмаар газар, ус, агаар, сансраас бүрдэж байсан байлдааны ажиллагааны театрын уламжлалт орон зайг мэдээллийн буюу кибер орон зай баяжуулсан юм. Ирээдүйн дайнуудад кибер орон зай нэн чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд дайсны мэдээллийн

дэд бүтэц, сэтгэл зүй нь цохилтын гол объект болох ажээ.

1993 онд АНУ-ын Батлан хамгаалахын сайд, Зэвсэгт хүчний штабын дарга нарын хорооны орлогч нар дайсны мэдээлэл, мэдээллийн тогтолцоонд нөлөөхийн сацуу өөрийн мэдээлэл, мэдээллийн тогтолцоог хамгаалж, аюулгүй байдлыг хангах замаар үндэсний цэрэг-дайны стратегиз дэмжих, тэтгэх, улмаар мэдээллийн давуу байдалд хүрэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа мөн гэж мэдээллийн дайныг тодорхойлсон байна³.

Тэгвэл С.П.Расторгуевын томъёоллоор: «Мэдээллийн дайн бол тавьсан зорилгодоо хүрэхийн тулд утга тээгчийг мэдээллийн аргаар устгах, өөрчлөх, нялзаах, хаахад чиглэгдсэн тодорхой зорилт бүхий, өргөн цар хүрээтэй үйл ажиллагаа мөн»⁴.

Ер нь судлаачид мэдээллийн дайныг янз бүрээр тодорхойлсон нь бий. Гэхдээ тэд нэг онцлог шинжийг санал нэгтэй хүлээн зөвшөөрдөг: мэдээллийн дайныг хэзээ ч тохиолдлоор, эсвэл тусгайлж хийдэггүй. Энэ бол дайны хажуугаарх дажин юм. Энэ бол мэдээллийг зэвсгийн хувиар тодорхой зорилготой, төлөвлөгөөтэй ашиглах үйл ажиллагаа юм. Тэгэхдээ тэрхүү мэдээллийг байлдааны талбар дээр ч, эдийн засаг, улс төр, нийгмийн салбарт ч ашиглаж болно. Мэдээллийн дайны объект нь дараах зүйл байдаг:

✓ Улс орны мэдээллийн дэд бүтэц буюу мэдээлэл харилцаа, тээвэр холбооны сүлжээ, цахилгаан станциуд, банк санхүүгийн тогтолцоо г. м.

✓ VIP-хүмүүсийн нууц код, баримт, дугаар, банкны данс зэргийг эвдэж ашиглах.

✓ Аж үйлдвэрийн тагнуул буюу патент бүхий мэдээллийг хулгайлах, онцгой чухал мэдээллийг гажуудуулах,

эсвэл устгах, өрсөлдөгчдийн тухай мэдээлэл цуглуулах г. м.

✓ Цэргийн бүхийл объект, тогтолцоог командлах, удирдах үйл явцад цахим түвшинд оролцох, «штабын дайн» явуулах, цэрэг-дайны харилцааны сүлжээнүүдийг жагсаалаас гаргах.

✓ Цэрэг-дайны зориулалт бүхий 150 мянган компьютер байршдаг Интернет даяар сүлжээ юм.

Мэдээллийн дайнд мэдээллийн давамгайлал гэсэн ойлголт голлох үүрэгтэй. Нөхцөл байдлын тухай мэдээллийг тасралтгүй хуримтлуулж, боловсруулахын сацуу дайсанд ийм боломж олгохгүй байх нь чухал бөгөөд ингэж чадсанаар мэдээллийн давамгайллыг бий болгодог. Ингэснээр байлдааны нөхцөл байдлын тухай бодит төсөөлөлтэй болж, өөрийн болон дайсны цэргийн үйл ажиллагааны талаар интерактив ойлголтыг бүрдүүлдэг.

«Мэдээллийн дайн» хэмээх ойлголтыг судлаачид янз бүрээр тодорхойлж, хамрах хүрээг нь өөр өөрийнхөөр тогтоосон байдаг боловч энэхүү нэр томъёо цэргийнхний дунд төрсөн бөгөөд бодит байлдааны ажиллагаатай зүйрлэж болохуйц ширүүн, аюултай, эцсийн ялалтанд чиглэгдсэн үйл ажиллагааг илэрхийлдэг. Мэдээллийн дайны номлолыг боловсруулсан цэргийн шинжээчид энэ нь штабын дайн, цахим дайн, психотрон дайн, сэтгэл зүйн дайн, кибернетик дайн болохыг тэмдэглэсэн байдаг.

Улмаар мэдээллийн дайн гэдгийг гарт баригдаж, нүдэнд харагддаггүй кибер орон зай дахь компьютерүүдэд «нуугдсан» боломжуудыг өөрийн болгох, ашиглах зорилгоор тодорхой хүчин (эвсэл, улс г. м.) явуулж байгаа үйл ажиллагаа гэж ойлгож болно. Хоёр тал хоорондоо харьцаанд орохгүй, мөн

алагдагсдын тоо маш цөөн (эсвэл огт үгүй) байдгаараа мэдээллийн дайн нь бидний ойлгодог дайнаас ялгаатай. Пентагоны нэгэн удирдах албан тушаалтан: «Хэн ч цэрэг биш, гэхдээ нөгөөтэйгүүр хүн бүр байлдааны ажиллагаанд оролцогч болох хөгжлийн тэр шатанд бид ойртож байна. Өдгөө дайны зорилго нь дайсны амьд хүч, зэвсэгт хүчнийг устгахад бус, харин хүн амын үзэл бодол, байр суурийг ганхуулах, нийгмийг нураахад оршино» гэж тэмдэглэсэн нь учиртай⁵.

Мэдээллийн дайнд эвдрэл, сүйрэл тохиолддоггүй. Тиймээс нийгэм өөрийнх нь мэдэлд байдаг хамгаалах механизмаа ажиллагаанд оруулдаггүй. Хүн ам ч мэдээллийн дайн өрнөж байгааг мэдэлгүй, анзааралгүй өнгөрдөг. Улс оронд хэдэн сарын турш мэдээллийн нөлөөллийг эрчимтэй үзүүлбэл засгийн газар солигдож болдог бөгөөд өөрт нь гаднаас шахалт үзүүлж байсныг хүн ам нь ч мэдэрдэггүй ажээ⁶.

Мэдээлэл харилцаа хөгжиж өргөжихийн хэрээр мэдээллийн дайн нь аливаа дайны салшгүй нэг хэсэг болжээ. Сүүлийн үеийн дайнуудаас хэдэн жишээ авъя. Вьетнамын дайны үеэр Хойд Вьетнамын засгийн газар хүн амын сэтгэл санааг өөдрөг байлгахын тулд америкчуудын бөмбөгдөлтөөс учирч буй хохирлын хэмжээг зориуд нуун дарагдуулах бодлого баримталж байв. Энэ тухай Бүгд Найрамдах Ардчилсан Вьетнам Улс дахь (одоогийн БНСВУ) ЗХУ-ын цэргийн атташегийн дэргэдэх шинжлэх ухаан-техникийн хэсгийн мэргэжилтэн Виктор Теплов ийн өгүүлсэн байдаг: «Өөрийн хүн амд ч, америкчуудад ч тэдний бөмбөгдөлт үр дүнд хүрэхгүй, талаар болж байгаа гэж ойлгуулахын тулд вьетнамчууд ихээхэн чармайж

байсан юм. <...> Тухайлбал: америкчуудын ээлжит довтолгооноос учирсан хохирлыг албан ёсны мэдээлэлд нэг үхэр, гурван гахай, долоон тахиа алагдсан, хүний амь эрсдээгүй гэх мэтээр дамжуулдаг байв. Тэгэхдээ ингэж мэдээлэхдээ алагдсан амьтны тоонд ч хязгаар тогтоодог байлаа»⁷.

АНУ-ын Батлан хамгаалах яам мэдээллийн дайнд гар татахгүй мөнгө хаяж байна. АНУ-ад дайсагнасан хандлагыг халж, тэдэнд найр тавьсан сэтгэл зүй бий болгох зорилгоор Иракийн ОНМХ-үүдэд зориулж захиалгаар улс төрийн мэдээ, нийтлэл бичих, нийгмийн реклам дамжуулах, хөгжөөнт нэвтрүүлэг бэлтгэх «кампанит ажил»-д Пентагон 300 сая доллар зарцуулахаар тогтсон тухай «The Washington Post» сонин 2008 оны 10-р сарын 3-ны дугаартаа нийтэлжээ. Энэ бол зэвсгийн хүчээр барьж тогтоохгүйгээ мэдээллийн хүчээр барьж тогтоож болохыг дээд түвшинд хүлээн зөвшөөрсний илрэл юм.

Г.Г.Почепцов мэдээллийн дайн амжилттай/амжилтгүй болох нь техникийн хүчин зүйлээс, юуны түрүүнд компьютерээс ихээхэн шалтгаалдгийг онцолсон байдаг⁸. Тэгвэл хүйтэн зэвсгийн үед ч мэдээллийн дайн явагдаж байжээ.

Мэдээллийн дайны улбааг олон мянганы тэртээгээс хайх хэрэгтэй. Түүхэн эх сурвалжаас үзвэл, Бага Азид аж төрж байсан эртний хетт аймгийнхан НТӨ 1312 онд Египетийн фараон II Рамзесийг худал мэдээллээр төөрөгдөлд оруулж, командалсан армийг нь Кадеш цайзны дэргэд (одоогийн Сири) бут цохиж, нутаг буцаасныг⁹ мэдээллийн дайны анхны тохиолдол гэж үздэг.

Хэдийгээр түүхийн бүхий л үед мэдээллийн дайн янз бүрийн хэлбэрээр

өрнөж байсан боловч Чингис хааныг онцгойлон үзэх нь зүйтэй. Тэрээр мэдээллийн дайны тухай ойлголтыг шинэ түвшинд гаргаж, онол, арга зүйг боловсруулж, практик дээр, тодруулбал, байлдааны нөхцөлд хэрэглэж, бодит үр дүнд хүрч чадсан юм.

Гэтэл «Мэдээллийн дайны түүх» хэмээх хоёр боть бүхий бүтээлийг зохиогч Н. Л. Волконский Чингис хааны мэдээллийн дайны тухай ганцхан ерөнхий өгүүлбэр оруулсан байдаг.

Тэгвэл Чингис хааны мэдээллийн дайн хэрхэн илэрч байв? Чингис хаан ээлжит аян дайнд мордохынхоо өмнө худалдаачдын дүрээр тагнуул туршуулуудын бүхэл бүтэн армийг илгээдэг байв. Тэд монголчууд шороон түмэн цэрэгтэй, хэнд ч дийлддэггүй, эсэргүүцэл үзүүлсэн хэнийг ч өршөөдөггүй, тулалдсан бүхнээ эрхшээлдээ оруулдаг тухай цуу яриа дэгдээж, хүн амын дунд айдас хүйдэс, түгшүүр тарьж, өөрийн хүчинд итгэх итгэлийг нь мохоож, эсэргүүцэл үзүүлэх зүрх зоригийг нь бөхөөдөг байжээ. Үүний сацуу бууж өгсөн ард түмнүүдий амийг хэлтрүүлдэг, тэднээс зөвхөн алба гувчуур л татаж, амар тайванд нь орхидог гэх өөр нэг мэдээлэл давхар тархдаг байна.

Энэ бүхнээс үзвэл Чингис хааны бодлого орчин үеийн мэдээллийн дайны тухай сонгодог ойлголтод яв цав нийцдэг. Чингис хааны мэдээллийн дайны үр дүнд түүний бодит болон болзмол дайснууд Монголын армитай учрахаасаа өмнө сэтгэл зүйн хувьд ялагдсан, сүр сүлдэнд нь дарагдсан байдаг байв.

XIII-XIV зууны үеийн түүхчид монголчуудын байлдан дагууллын шалтгааныг тэдний тоо томшгүй олон цэргээр нэгэн дуугаар тайлбарлаж байсан нь үнэндээ мэдээллийн дайны үр дагавар байсан юм. Тухайлбал:

мажар лам Юлиан «Монгол цэргийг дөч хуваасан ч гэсэн зөвхөн түүний нэгэнтэй нь тэнцэх хүч дэлхий дээр хэрхэвч олдохгүй. Монгол улс тийм үлэмж их цэрэгтэй» гэж бичсэн байдаг¹⁰. Тэгвэл Италийн жуулчин Жованни дель Плано Карпини Киев хотыг 600 мянган цэрэг бүслэн хаасан гэж тэмдэглэсэн байдаг бол Мажарын түүхч Симон Унгар луу 500 мянган монгол-татар цөмрөн орсон гэж бичсэн нь бий. Мөн Татарын их цэрэг замд явахад нэг захаас нь аваад нөгөө зах хүртэл уртаараа 20 хоног, өргөнөөрөө 15 хоног явж хүрэх талбай эзэлдэг, тэднийг бүтэн тойроход 70 хоног өдөр шөнөгүй явах хэрэгтэй гэсэн цуу яриа тэр үед дэлгэрсэн байв.

Сонирхуулж хэлэхэд, мэдээллийн дайнд Чингис хаанаас дутуугүй ач холбогдол өгч, түүний цэргийн жанжны өвийг судалж байсан Францын эзэн хаан I Наполеон өөрийн цэргийн тоог байнга хэд нугалж мэдээлдэг, ингэхийг сонины эздээс ч, холбоотнуудаасаа ч шаарддаг байжээ. Москвад эзэмдээд байхдаа тэрээр өөрийн холбоотон Австри, Бавари, Вюртембергийн хаадад дараах агуулгатай захидал илгээсэн байдаг: «Надад нэмэлт хүч илгээхийг би хүсч байгаагаар үл барам энэхүү нэмэлт хүчийнхээ тоог нэмэгдүүлж мэдээлэхийг би шаардаж байна. Та бүгд над руу илгээж байгаа цэргийнхээ тоог хоёр дахин нэмэгдүүлж мэдээлэх үүргийг сонинууддаа даалгагтун»¹¹.

Тооны ихээр дайсныхаа зүрхийг үхүүлэхээс гадна (эсэргүүцэл үзүүлээд нэмэргүй) үг дуугүй бууж өгсөн тохиолдолд энэрэл өршөөл үзүүлэхээ монголчууд мэдэгддэг байсан нь хий хоосон амлалт байсангүй. Хятадад ч, Хорезмд ч, Оросод ч монголчуудын өмнө толгой бөхийлгөсөн хотууд багахан хэмжээний алба гувчуур бариад (агт морьд,

цэргүүдэд хүнс тэжээл өгөх) өнгөрдөг байв. Түүхийг үзэл суртлын дагуу намын заавраар бичдэг байсан цаг үед Оросын судлаачид бидний өвөг дээдэс бүгд Монголын булаан эзлэгчидтэй баатарлагаар тулалдаж алагдсан, нэг ч хот бууж өгөөгүй хэмээн мэлздэг байлаа. Тэгвэл 1238 онд Оросын Ярославль, Ростов, Углич, Тверь зэрэг хот монголчуудад эсэргүүцэл үзүүлэлгүй үүд хаалгаа нээсэн учир дайны хатууг амсалгүй өнгөрчээ¹². Энэ бол монголчуудын мэдээллийн дайн үр дүнгээ өгч байсны илрэл юм. Эртний Хятадын цэргийн онолч Сүнз «Дайтахуйн урлаг» бүтээлдээ: «Дайтахуйгээр дайснаа дагаар оруулахуй болвоос сэцэн мэргэний чанад дээд нь буюу»¹³ гэж бичсэн байдгийг санах нь зүйтэй.

Монголчуудын явуулж байсан мэдээлэл-сэтгэл зүйн дайн бодит үр дүнд хүрч байсныг арабын алдарт түүхч ибн ал-Асирын (1160-1234) «Нийтийн түүхийн бүрэн товчоо»-ноос харж болно. Зохиогч өөрөө Монголын байлдан дагууллын үед амьдарч байсан, дэлхийн түүхийг өөр гольдрол руу эргүүлсэн энэхүү үйл явдлын амьд гэрч байсан учир түүний бичиж үлдээсэн зүйл үнэ цэнэтэй:

«Тэдний [монголчуудын] хараахан ирээгүй улс орнуудад хүн бүр айдас хүйдэстэй унтахаар хэвтэж байна. Тэдний ирэхийг бүгд хүлээнэ»¹⁴, «Тэнгэр хүмүүсийн зүрх сэтгэлд айдсын үрийг тарьсан учир тэдний [монголчуудын] тухай сонссон хүн бараг л

итгэхгүй тийм зүйлийг надад хуучилсан юм. Морьтой монгол эр нэгэн тосгонд ороод гэл үү, олон хүн явж өнгөрдөг зам дээр зогсоод гэл үү, хүмүүсийг нэг нэгээр нь алж гарчээ. Гэтэл түүнийг хэн ч эсэргүүцэх нь байтугай гар ч хүрч зүрхлээгүй байна. Мөн нэг монгол эр манайхны нэгийг барьж авчээ. Гэвч түүнийг хороох ямар нэг зэвсэг өөрт нь байгаагүй учир: "Толгойгоо газар тавиад хүлээж бай. Байрнаасаа хөдөлж болохгүй шүү" гээд явжээ. Манай хүн толгойгоо газар тавиад хүлээж байх зуур монгол эр сэлэм олж ирээд түүнийг хөнөөсөн байна. Сонссон өөр нэг явдлын тухай хуучилъя. Манайхны нэг ингэж өгүүлсэн юм: "Би 17 эрийн хамт замд явж байтал

«

Хэдийгээр түүхийн бүхий л үед мэдээллийн дайн янз бүрийн хэлбэрээр өрнөж байсан боловч Чингис хааныг онцгойлон үзэх нь зүйтэй. Тэрээр мэдээллийн дайны тухай ойлголтыг шинэ түвшинд гаргаж, онол, арга зүйг боловсруулж, практик дээр, тодруул-бал, байлдааны нөхцөлд хэрэглэж, бодит үр дүнд хүрч чадсан юм.

»

морьтой монгол тааралдлаа. Тэрээр биднийг бие биеийнхээ гарыг хүлэхийг тушаалаа. Замын нөхөд маань түүний тушаалыг биелүүлж эхлэв. Би тэдэнд: "Наадах чинь ганцаараа байна шүү дээ. Бүгдээрээ наадхыг чинь нухчихаад зугатвал яасан юм бэ?" гэхэд тэд: "Бид айгаад байна" гэв. Би: "Наадах чинь биднийг одоо ална шүү дээ. Тиймээс урьтаж түүнийг хорооё. Тэнгэр биднийг ивээх ч юм билүү" гэсэн боловч нөхөд маань энэ тухай бодохыг ч хүсэхгүй байв. Бурханы нэрийг барьж андгайлахад энэ үнэн түүх шүү. Иймд би хутгаа гаргаж түүний аминд хүрсэн. Ингээд л бид бүгд зугатаж амь мултарсан даа". Ийм жишээ олныг дурдаж болно»¹⁵.

Мэдээллийн дайн илэрдэг өөр нэг талбар бол яах аргагүй тагнуулын

салбар юм. Энэ тал дээр монголчууд тухайн үеийн улс үндэстнүүдээс хол тасархай байв. Монголчуудыг гүйцэх тагнуулын сүлжээг гагцхүү Дэлхийн хоёрдугаар дайны үед л дэлхийн даяар гүрнүүд бий болгож чаджээ. Чингис хаан дайсны удирдлага, цэрэг, хүн ам, улс төрийн ба нийгэм-эдийн засгийн байдал, цэрэг-дайны чадавхи, хүчтэй болон сул талын тухай бүхий л мэдээллийг цуглуулж, цэгнэн үзсэний үндсэн дээр ялагдах өчүүхэн магадлал тэглэгдсэний эцэст аян дайнд морддог байв. Сартуулыг дайлаар мордохын өмнө Чингис хаан Мөнх хөх тэнгэрт гурван өдөр, гурван шөнө зогсолтгүй залбирдаг. Чингэхдээ тэрээр өөрийн болон өрөөлийн хүчийг дэнслэн үзсэн, үүний үндсэн дээр шийдвэр гаргасан байхыг үгүйсгэх аргагүй.

З алгамжлагчид нь дайныг Чингис хааны билиг сургаалийн дагуу явуулж байв. Тухайлбал: Оросын ванлигууд, Зүүн болон Төв Европт явуулсан Бат хааны аян дайн нь Чингис хаан Хорезмыг дайлаар мордсоныг олон шинжээрээ санагдуулдаг. Олон тооны мэргэжлийн тагнуул туршуул Орос, Европын орнуудын цэрэг-стратегийн байдлыг хөндлөн гулд судалж, Бат хаан үзээгүй, учраагүй дайснаа урьдаас мэдэж байлаа. Сүвэдэй баатар венеци иргэдээр дамжуулан Европын нийгмийн бүх давхаргынхантай холбогдсон байв¹⁶.

Их Монгол улсын үеийн тагнуулын үйл ажиллагааны тухай сонирхолтой судалгаа нийтлүүлсэн М.Цогтоо энэ талаар: «Монголын их гүрэн Орос, Зүүн Европыг байлдан дагуулахад уламжлалт цэрэг-тагнуулын үйл ажиллагааг нэн өргөн хүрээтэй болгон явуулжээ. Дайсныхаа байлдах арга ухаан, зэвсэглэл, хүчин чадлын талаар чухал мэдээлэл цуглуулахын зэрэгцээ олон

зуун туршуулаа нэвтрүүлэх, Европын лалын худалдаачдаас гадна Европын эзлэгдсэн болон бусад орны янз бүрийн давхаргын хүмүүсийг элсүүлэн ашиглах, элч төлөөлөгч, тагнах, хорлон сүйтгэх баг цэрэг илгээх зэрэг арга замаар өргөн хүрээтэй тагнуулын үйл ажиллагааг тухайн улс орнуудын бүх талын онцлогт зохицуулан чадварлаг зохион байгуулж байжээ. Уг үйл ажиллагааныхаа ачаар Орос болон Зүүн Европын орнуудын цэрэг, нийгэм, улс төр, эдийн засаг, газар нутаг, байгал цаг уур зэрэг асуудлаар ихээхэн мэдээлэл цуглуулж, үр дүнтэй ашиглаж чадсанаар стратегийн маш том зорилтыг хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлжээ» гэж бичсэн байдаг¹⁷.

Мэдээллийн дайны зорилго зөвхөн дайснаа айлган сүрдүүлэх, өөрийн хүчийг дөвийлгөхөд оршдоггүй. Мэдээллийн дайн нь өөрийн хүчинд итгэх итгэлийг бэхжүүлж, зүрх зоригийг бадрааж, үлгэр дууриал авахуйц зүйлийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлахад мөн чиглэгддэг. Чингисийн чулууны бичиг (1224-1225)-ийг доктор Ж.Батбаатар сэтгүүл зүйн, түүний дотор мэдээний дурсгал мөн гэсэн сонирхолтой дүгнэлт хийсэн байдаг. Тэрээр «Суурь сэтгүүл зүй» бүтээлдээ: «Бичиг соёлын эртний өв уламжлалтай монголчуудын түүх, соёлын дурсгалын дотор ч тухайн үйл явдал, онцгой содон зүйлсийн тухай дамжуулсан цөөнгүй "мэдээ" хадгалагдан үлдэж бидний үед уламжлагдан ирсэн ажээ. Сонгодог бичгийн өмнөх үеийн төдийгүй, бичмэл "мэдээ"-ний анхны тод дурсгал хэмээн үзэж болох "Чингис хааныг Сартуул иргэд дайлж бууж Хамаг Монгол улсын ноёдыг Бүх-сочигай хурсанд Есүнхэ онтудурын гурван зуун гучин таван алдас-т онтудулаа" хэмээн эцэг дээдсийн бараг найман зуун жилийн тэртээ чулуун

дээр бичиж үлдээсэн энэхүү мэдээ чингис хаан Сартуулыг байлдан дагуулсан аян дайнаас эх нутагтаа буцах замд Бух-сочигай хэмээх газар болсон үйл явдал, Хасарын хүү Есүнхэ мэргэний 335 алд газар мэргэн харваж тогтоосон дээд амжилтыг»¹⁸ сурталчилсан хэмээн дүгнэжээ.

Бид чингисийн чулууны бичгийг сэтгүүл зүйн төдийгүй, мэдээллийн дайны дурсгал гэж үзэж байгаа юм. Монголын эрхий мэргэн харваач 335 алд газар алдалгүй онодгийг тунхаглан зарласнаар Есүнхэ мэргэнээс дутахгүй харвах хүслийг монголчуудад төрүүлэхийн сацуу дайсны зүрхэнд шар ус хуруулсан мэдээлэл бол энэ мөн.

Мэдээллийн дайн хоёр үзүүртэй бөгөөд нэг нь бодит болон болзмол дайсан руу чиглэдэг бол нөгөө нь дотогшоо ханддаг, өөрийн хүн амыг нягтруулах, нэгэн үзэл санаагаар цэнэглэх зорилготой байдгийн нотолгоог бид дараах тодорхойлолтоос олж болно. «[Мэдээллийн дайны] нөлөөллийн зорилт нь бүтээгч ч, нураагч ч шинжтэй байдаг. Эхний тохиолдолд нийгмийг бүрдүүлэгч улс төрийн, сэтгэл зүйн болон бусад хүчин зүйлийг бэхжүүлэхэд тэрхүү үйл ажиллагаа чиглэгддэг. Үүний үр дүнд нийгэм гадна, дотны сөрөг нөлөөллийн эсрэг дархлаатай болдог. Удаах тохиолдолд үйл ажиллагаа нь улс орны дотоодод ч, хилийн чанадад ч тогтворгүй байдал үүсгэх, түүнийг дэврээхэд чиглэгддэг»¹⁹.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Чингис хаан мэдээллийн дайны онол, арга зүйг өмнөх үеийн сургамж болон өөрийн туршлаган дээр тулгуурлаж төгс боловсронгуй болгож хөгжүүлснийг Доголон Төмөр, Наполеон, Гитлерээс авахуулаад хожмын үеийн бүхий л агуу байлдан дагуулагчид хуулбарлан дууриаж байжээ.

Ишлэл

- ¹ Вершинин М. С. 2006. Политическая коммуникация в информационном обществе. М., с. 26.
- ² Там же, с. 68.
- ³ Зверинцев А. Б. 2007. Коммуникационный менеджмент. Рабочая книга менеджера PR: 2-е изд., испр. СПб., с. 88.
- ⁴ Расторгуев С. П. 2008. Информационная война. М., с. 25.
- ⁵ Малькова Т. В. 2006. Массы. Элита. Лидер. М., с. 32.
- ⁶ Кочетков В. В. Социально-психологическая составляющая информационной войны // <http://www.infwar.ru/article.php?num=22>
- ⁷ «Коммерсантъ», 7 марта 2000.
- ⁸ Почепцов Г. Г. 2001. Информационные войны. М., с. 18.
- ⁹ Разин Е. А. 1994. История военного искусства. СПб., с. 51-53.
- ¹⁰ 1940. Письмо брата Юлиана о монгольской войне // Исторический архив. М.-Л., т. 3, с. 90.
- ¹¹ Волковский Н. Л. 2003. История информационных войн. М., т. I, с. 167.
- ¹² Гумилёв Л. Н. 2003. Древняя Русь и Великая степь. М., с. 474.
- ¹³ Ишлэлийг: Чимэдцэеэ М. 2012. Бидний мэдэх хийгээд эс мэдэх Хятад орон: сэтгэлгээ, соёл. УБ., 140 дэх тал.
- ¹⁴ 1940. Материалы по истории Азербайджана из Тарих-ал-камиль (полного свода истории) Ибн-ал-Асира. Баку, с. 137.
- ¹⁵ Там же, с. 176-177.
- ¹⁶ Хара-Даван Э. 1992. Чингис-хан как полководец и его наследие. Алма-Ата, с. 202.
- ¹⁷ Цогтоо М. 2008. Их Монгол улсын тагнуулын үйл ажиллагаа. УБ., 50 дахь тал.
- ¹⁸ Батбаатар Ж. 2010. Суурь сэтгүүл зүй. УБ., 40 дэх тал.
- ¹⁹ Почепцов Г. Г. 2000. Психологические войны. М., с. 41.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Вершинин М. С. 2006. Политическая коммуникация в информационном обществе. М.
2. Волковский Н. Л. 2003. История информационных войн. М. В 2-х тт.
3. Зверинцев А. Б. 2007. Коммуникационный менеджмент. Рабочая книга менеджера PR: 2-е изд., испр. СПб.

4. Кочетков В. В. Социально-психологическая составляющая информационной войны //

<http://www.infwar.ru/article.php?num=22>

5. 1940. Материалы по истории Азербайджана из Тарих-ал-камиль (полного свода истории) Ибн-ал-Асира. Баку.

6. Мухин А. А. 2000. Информационная война в России. Изд-ва «Центр Политической Информации», «ГНОМ и Д».

7. Панарин И., Панарина Л. 2003. Информационная война и мир. Изд-во «Олма-Пресс».

8. Почепцов Г. Г. 2000. Психологические войны. М.

9. Почепцов Г. Г. 2001. Информационные войны. М.

10. Расторгуев С. П. 2008. Информационная война. М.

11. 2008. Техника дезинформации и обмана. М.

Резюме

Настоящая статья посвящена методологии ведения информационной войны в эпоху монгольских завоеваний – в XIII в. Как считает автор, Чингисхан являлся гениальным теоретиком информационно-психологических войн, который на практике сумел воплотить в жизнь свои идеи. Монгольский император и полководец являлся выдающимся мастером оказания информационного давления на противника, выброса дезинформации, обеспечения информационного превосходства над врагом и мн. др.